

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН MV-007944 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААРТАЙ “ХАР ТЭВШ” НЭРТЭЙ НҮҮРСНИЙ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ БА ГОЛ ШААРДЛАГА

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиар тухайн төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагааныхаа хүрээнд төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/-аар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээхээр зохицуулсан.

Хуульд БОАЖЯ нь тухайн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгож, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-өөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

“Биг могул коул энд энерги” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Биг могул коул энд энерги” ХХК нь байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хувиарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан. Мөн БОАЖЯ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон тус хуулийн 9.12-т зааснаар хянуулсан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулах бөгөөд уг дүгнэлт, төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үндэслэн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ тухайн хуулийн 9.5-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын дагуу шийдвэрлэх юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт

тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДСЭН ЗОРИЛТУУД, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн хүрээнд “Биг могул коул энд энержи” ХХК-ийн дагаж мөрдөн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Майндата” ХХК-ийн боловсруулсан Хар тэвш нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр өгсөн чиглэл болон өмнө хийгдсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсрууллаа.

Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-р хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, 2017 оны 5-р сард батлагдсан Хог хаягдлын тухай хууль болон түүнтэй холбогдсон бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргийг тусгасан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт:

1. Хар тэвш нүүрсний ордыг ашиглах төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн малчин иргэдийн нутагшил нийгэм, эдийн засгийн байдалд болон түүх соёлын үнэт зүйлсэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах;
2. Үйл ажиллагааны явцад төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг хянаж, илрүүлж гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт оршино.

Монгол орны байгаль орчны салбарт 2012 онд шинэчлэн баталсан хуулийн гол шаардлагуудын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын ажлын гол үр дүнг тоймлон авч үзэхэд “Биг могул коул энд энержи” ХХК-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын 7944А тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэвш” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн гол чухал зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно.

Хар тэвш нүүрсний уурхайн үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагч нь тоос тоосонцор юм. Нүүрсний ил уурхайн үйл ажиллагаа нь их хэмжээний тоосжилт үүсгэдэг ч уурхайн онцлог, ашиглалтын арга зэргээс шалтгаалаад үүсэж буй тоосны хэмжээг тооцоолох тогтсон арга аргачлал байдаггүй. Ил уурхайгаас нүүрс олборлохын тулд их хэмжээний хөрс чулуулгийг хуулж зөөвөрлөх шаардлагатай байдаг ба энэ үйл ажиллагаанд ашиглагдах экскаватор, ачигч, зөөврийн ачааны машин эсвэл туузан дамжуурга зэрэг машин тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанаас их хэмжээний тоос тоосонцор үүсдэг. Тархалтын загварын үр дүнгээр уурхайн хамгийн их нөлөөлөл үүсгэж байна эх үүсвэр нь уурхайн гадаад тээвэрлэлт байна. Уурхайн гадаад тээврийн замаас үүсэх тоосжилт зам орчим 200 метр дотор стандартын ЗДХ давах боловч замаас алслах тусам агууламж нь буурч стандартын хэмжээнд хүрч буурахаар байна. Уурхайн кемп орчмын талбай нь цэвэр агаарын ангилалтай боловч хүчтэй шороон шуурганы нөлөөн дээр нэмэлтээр тоосжилт үүсгэж агаарын чанарын индексээр бохирдолтой ангилалд орж болзошгүй. Уурхайн ажилчдын бүсэд агаарын чанарын индекс тархалтын загварын үр дүнгээр ухаш орчим их бохирдолтой ангилалд байж болзошгүй учир гол тоосжилтын эх үүсвэр болох уурхайн дотоод тээврийн замыг тогтмол услах, тоосжилт бууруулах арга аргачлал нэвтрүүлэх, ажилчдыг тоосжилтоос хамгаалсан хэрэгслүүдээр хангаж ажиллах шаардлага үүсч болзошгүй. Мөн уурхайн тоосжилтыг хэмжих хэмжилтийн багаж төхөөрөмжөөр тасралтгүй мониторинг хийх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас элэгдэл эвдрэлд орсон нийт 12.75 га талбайд ургамалжуулах биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр, хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байхаар хэлбэршүүлэх бөгөөд шимт хөрсний овоолгын өндрийг 5 метрээс илүүгүй байхаар үүсгэх нь зүйтэй.

Олборлолт, хөрсний овоолго, зам, уурхайн барилга байгууламжийн доор дарагдах шууд нөлөөллөөс гадна уурхайгаас үүсэх тоосжилт нь ургамлан нөмрөгт шууд бусаар сөргөөр нөлөөлнө. Тоосны тархалт тооцоолсон үр дүнгээс харахад тэсэлгээнээс үүссэн тоос 2.0 км хүртэл зайд тархах ба уурхайн ашиглалтын талбайгаас гадна тийш 2 км-ийн радиуст байгаа ургамлан нөмрөг шууд бус дам нөлөөлөлд өртөнө. Төсөл хэрэгжиж дууссаны дараа нөхөн сэргээлтийн зөвлөмжид заасны дагуу биологийн нөхөн сэргээлтийг тухайн бүс нутгийн унаган ургамлаар хийж гүйцэтгэвэл зүйтэй.

Ил уурхайн олборлолттой холбогдох гол асуудал нь газрын доорх устай холбоотой байдаг. Шүүрлийн усыг соруулан ил гаргаж асгах, ууршуулах нь усны нөөцийг багасгах, хомсдол үүсгэх, газрын доорх усны түвшин бууруулах, газрын доорх усны горимд сөргөөр нөлөөлөх үр дагавартай. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг зумпанд цуглуулж зумпнаас шахмал түлшний цехийн усан сан руу татаж хэрэглэх боломжтой.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга

хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардалыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу “Биг могул коул энд энерги” ХХК-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын 7944А тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэвш” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг төслийн хүчин чадлыг өргөтгөх, өөрчлөх бүрд нэмэлт тодотгол хийж байх шаардлагатай бөгөөд 2024 оноос хойш 5 жилийн дараа буюу 2028 оны төгсгөлд төслийн үйл ажиллагаа, энэхүү төлөвлөгөөний болон жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны явцад хийсэн дотоод болон хөндлөнгийн аудитын дүн, нүүрс олборлох үйл ажиллагааны өөрчлөлттэй уялдуулан дахин 5 жилээр хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаар батлуулах шаардлага тавигдана.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай

5.1. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөл нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
Агаарын чанар үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах									
Үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч агаарын чанарыг бага хэмжээгээр доройтуулна.	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	Уурхайн ашиглалтын талбайн тоос үүсгэх гадаргуу	-	500.0	-	500.0	2024 он	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. 2 MNS4585:2007	
	Уурхайн ачиж буулгах талбай болон дотоод замыг услах, хөрс барьцалдуулагч шингэнээр шүрших (CaCl, MgCl-н хольц, FLOSET SR71 г.м) туршилт судалгаа хийх	Уурхайн дотоод тээврийн зам овоолгууд					Үйл ажиллагааны зардал	2024 он	
	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах	Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам	км				Үйл ажиллагааны зардал	2024 он	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS 4585:2016
	Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах. (бусад уурхайн жишгийн дагуу 200 мото/цаг) Хөдөлгүүрээс гарах утааны найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх хэрэгсэл төхөөрөмж тавих /TWCAT002, TWCAT0061 маркийн шүүлтүүр/	Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх хүнд механизмуудад	Ширхэг		400.0		400.0	2024 он	MNS5885:2008 MNS 5013:2009 MNS 5014:2009 MNS 5919:2008

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Уурхайн хотхонд байрлах уурын зуухны янданд шүүлтүүр суурилуулах	Уурын зуух	Ширхэг	100.0	-	100.0	2024 он	
	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх машин техникүүдэд		500.0		500.0	2024 он	ХАБЭАТ хууль
	Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	-	-	-	2024 он	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2016
	Уурхай дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	Ширхэг			200.0	2024 он	
	Замын ачааллын хяналтыг тэнцвэржүүлэх. Шороон замаар зорчих ачааны, автомашинуудын хоорондын зайг 20 секундээс 30 м-с их байхаар хугацаа болон хоорондох зайг тогтоох.	Төслийн дотоод тээврийн зам	-	-	-	ҮАЗ	2024 он	
	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн бүх ажилчдад				ХАБЭА-н зардлаас	2024 он	MNS 5080:2023 MNS 6768 : 2019 MNS 0012- 13:91

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Орчны бохирдол, хөрс, ургамал, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл багасна	Уурхайн гадаад тээврийн замыг хатуу хучилттай болгох чиглэлээр шат дараалалтай арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллах/Ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжтэй хамтрах /	Гадаад тээврийн зам				Үйл ажиллагааны зардал	2024 он	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоол
Хөрс хуулах, нүүрс олборлоход тэсэлгээ явуулснаар агаар орчинд их хэмжээний дуу шуугиан, чичиргээ болон тоосжилт үүсгэж улмаар хөрсний найрлага дахь эрдсийн жижиг тоосонцор үүснэ	-Тэсэлгээнээс гарах шороог багасгах үүднээс “усан дэр” ашиглах -Өрөмдлөгийн үед усаар чийгшүүлж байх -Салхи, шуурга ихтэй үед тэсэлгээний үйл ажиллагаа явуулахгүй байх - Тэсэлгээ хийх цаг хугацааг тухайн үеийн салхины чиглэл, хурд гэх мэт цаг агаарын үзүүлэлттэй уялдуулан хийж байх	Өрөмдлөг, тэсэлгээ хийх бүрт	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
	Нүүрс ачсан бүх тээврийн хэрэгсэл ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах	Тээвэрлэлт хийж буй бүх тээврийн хэрэгслүүдэд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	
2. Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах								
Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шим, чийг буурах, бохирдох, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрснийг 20-25 см зузаан тайгаар хуулж овоолгод хадгалах	Төслийн хүрээнд, Уурхайн эдэлбэр газарт				Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 5916:2008
	Шимт хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглахгүй 2 жилээс дээш хугацаагаар хадгалах бол – ургамалжуулах	Уурхайн эдэлбэр дэх овоолгуудад						
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон	Уурхайн эдэлбэрт хяналт тавих		500.0		500.0	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль, Газрын

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах							тухай хууль MNS 3307:1991, 17 MNS 3308:1991
	Машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын талбайд хийх, хучилт хийх, урсгал засварыг тогтмол гүйцэтгэх Ахуйн хатуу, шингэн хог хаягдал болон химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, устгах, зайлуулах, тогтмол хяналт тавьж ажиллах	Уурхайн засварын талбайд				Үйл ажиллагааны зардал	2024 он	
	Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид, жолооч, операторуудад				Үйл ажиллагааны зардал	2024 он	
	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллах	Уурхайн ашиглалтыг тогтворжуулах				Үйл ажиллагааны зардал	2024 он	
Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах								
Төсөл хэрэгжиж буй талбайн газрын доорх усны нөөц хомсдох	Уурхайн шүүрлийн ус болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй гүний худгаас тогтмол хугацаанд дээж авч бохирдлыг хянах, зохих стандартад заасан ЗДХэмжээнээс давсан тохиолдолд зохих арга хэмжээнүүдийг жил бүрийн БОМТөлөвлөгөөнд тусган сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг арилгах, таслан зогсоох ажлыг тогтмол авч хэрэгжүүлж ажиллах	Уурхайн шүүрлийн ус болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй гүний худаг	-	-	-	ОХШХ-ийн дагуу	2024 он	Усны тухай хууль
	Ашиглалтын талбайд гидрогеологийн нарийвчилсан судалгаа хийлгэх.	Төслийн хүрээнд				Ажил гүйцэтгэлийн гэрээний	2024 он	Усны тухай хууль

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

						үндсэн дээр		
	Гүний усны түвшин бууралтыг хэмжиж байх, ашиглалтын талбайн нөлөөллийн бүсэд байрлах малчны худгуудыг хамруулж ажиллах	Төслийн хүрээнд				ОХШХ-ийн дагуу	2024 он	
Шүүрлийн ус шавхалтаас газрын доорх усны горим, нөөцөд сөргөөр нөлөөлж усны түвшин буурч болзошгүй	Ил уурхайн дэргэд газрын доорх усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооног байгуулах, тогтмол хэмжилт дээжлэлт хийж байх	Уурхайн ухшийн дэргэд			1-2	4 500.0	2024 он	Усны тухай хууль БОАЖ, ЭМСайдын 2009 оны 51/75 дугаар тушаал MNS ISO 5667-24 1:2002
	Шүүрлийн усыг татан зайлуулж хөв цөөрөм байгуулах. Усны мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх.	Төслийн талбайд		5000.0		5000.0	2024 он	
Төслийн хэрэгцээнд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэн хэрэглэж багийн төвийн хүн амын усан хангамжид сөрөг нөлөө үзүүлж болзошгүй	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих	Гүний худаг Шүүрлийн ус татах хэсэгт	Ширхэг	100.0	2	200.0	2024 он	Усны тухай хууль БОНХСын А-156-р тушаал “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах								
Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устах	Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах	Ажилчдын хотхон, барилга байгууламжийн гадна талбайд		1 000.0	-	1 000.0	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль
	Биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах үрийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор нутгийн ургамлын үр түүх, нөхөн сэргээлтийн туршилт судалгааны талбай бий болгох	Ашиглалтын талбайд		2 000.0	-	2 000.0	2024 он	MNS 5914:2008 MNS 5917:2008

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Шилийн сар, шонхор зэрэг махчин шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл үүр барьж өгөх	Төслийн талбай түүний нөлөөллийн бүсд	250.0	-	250.0	2024 он	Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Машин зам дагуу амьтдыг мөргөх, дайрах осол аваар гарах нь элбэг байдаг	Осол гарч болзошгүй цэгүүд болон хүн, амьтан, мал гардаг хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах Амьтан дариагдасан тохиолдол бүрийн мэдээлж байх талаар жолооч операторуудад сануулж байх	Уурхайн тээврийн зам			Үйл ажиллагааны зардал	2024 он	
Нийт					15 150.0		

1.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 2. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
1	Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	2 жилээс дээш хугацаагаар хадалах шимт хөрсний овоолгыг ургамалжуулах	м ²	2000.0	-	2000.0	2024 он	MNS 5917:2008 MNS 5916:2008
2	Хаалтын арга хэмжээ	Уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн арга хэмжээнд жил бүр хуримтлуулах хөрөнгө	Төслийн хэмжээ энд	-	-	ҮАЗ	2024 он	MNS 5915:2008

“Биг могул коул энд энерги” ХХК нь “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэл 5000 ширхэг мод Ойн газартай гэрээ байгуулсан. “Хар тэвш” төслийн хүрээнд 2024 онд 500 ширхэг модыг тарихаар төвлөлөө.

Мод сөөгийг тарихдаа MNS 6253-1:2011 Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх. Ерөнхий шаардлага, MNS 6253-2:2011, Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага, MNS 6253-3:2011 Мод, сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага зэрэг стандартуудыг баримтлан ажиллана.

Хүснэгт 3. Мод тарих ажлын зардал

№	Ажлын нэр	тарих модны тоо	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал мян.төг
1	Хөрс боловсруулан сайжруулах ажлын зардал		500	500
2	Сөөг сөөгөнцөр	500	3	1500.00
3	Модны нүх ухах зардал	500	2.5	1250.00
4	Тарилт, арчилгаа, усалгааны зардал	500	Үйл ажиллагааны зардал	-
5	Механизмын зардал 15%		15%	488.0
6	Бусад зардал, 10%		10%	325
7	Дүн			4063.0

1.1. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
	Ургамлан нөмрөг түүний төрөл зүйлийг хамгаалах	Ашиглалтын талбайн болон нөлөөллийн бүсийн ургамлын нарийвчилсан судалгаа хийлгэж. Ховор нэн ховор ургамлын бүргэл гаргах. Хамгаалах шаардлагатай ургамлыг хашаалж хамгаалах	Төслийн талбай нөлөөллийн бүс		-	2 000.0	2024 он	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах	Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд		-	2 000.0	2024 он	
	Зэрлэг ан амьтан ундаалах уст цэгийг хамгаалах	булгийн эхийг хашиж хамгаалах, ундарга, усны чанарыг тогтмол хянаж ажиллах	Дэрсэнэ худгийн булаг	-	-	2 500.0	2024 он	
	Нутгийн иргэдэд болон уурхайн нийт ажилчидад байгаль хамгаалах талаар таниулах, уурхайн байгаль хамгаалах ажилд тэдний хяналтыг бий болгох	Нутгийн иргэдэд нөхөн сэргээлт хийх, мод тарих, байгаль хамгаалах талаар сургалт явуулах	Нутгийн иргэд болон сонирхогч талууд	-	-	4 000.0	2024 он	
		Баянжаргалан сумын нутаг дэвсгэр дэх биологийн олон янз байдлын талаар самбар,				1 000.0	2024 он	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		ухуулах хуудас гаргах, сургалт зохион байгуулах						
	Нийт					11 500		

1.2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1		2	3	4	5	6	7	8	9
Ахуйн хог хаягдал									
1	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	БОАЖСайдын А/349 дугаар тушаалын
2		Ахуйн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын ЗДТГазартай байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол
3		Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах	Төслөөс гарах хог хаягдал	-	1500.0	-	1500.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль
4		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, засварлаж байх	Төслийн хүрээнд	-	100.0	-	100.0	2024 он	Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйл
5		Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	Хог хаягдлын тухай хууль
6		Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он сар бүр тогтмол	Хог хаягдлын тухай хууль
7		Дахин ашиглах боломжтой ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээлэн нийлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он сар бүр тогтмол	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэви” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
9	Бие засах газар ахуйн бохир усны нөлөөгөөр байгаль орчин бохирдох	Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлж байх	Уурхайн бие засах газар бүрийг	-	100.0	-	100.0	2024 он Дулааны улиралд тогтмол	Хог хаягдлын тухай хууль
Аюултай хог хаягдал									
11	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах, түр хуримтлуулах цэгийг тохижуулах	Засварын талбайд	-			Үйл ажиллагааны зардал	2024 он	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
12		Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт улиралд нэг удаа нийлүүлэх, гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	-			Үйл ажиллагааны зардал	2024 он	
13		Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч	Төслийн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэвш” нэртэй нүүрсний уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
		саармагжуулах арга хэмжээ авах							
14		Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамааран хог хаягдлын цэгт хамгаалалтын бүс хашаа, хашлага татах. Хамгаалалтын бүсийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлуудыг эмх цэгцтэйгээр байршуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Хог хаягдал түр хадгалах цэгүүдэд				Үйл ажиллагааны зардал	2024 он	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол

1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдол нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцахаар заасан байдаг.

Төсөл хэрэгжүүлэгч нь “Биг могул коул энд энерги” ХХК нь MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэвш” нэртэй нүүрсний ордын талбайд айлын өвөлжөө, хаваржаа байхгүй тул энэ чиглэлээр БОМТ-нд тодорхой ажил тусгагдахгүй болно. Гэвч цаашид нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгох шаардлага гарвал харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Уурхайн ойр, орчим болон нөлөөллийн бүсэд нутаглаж амьдардаг иргэд	Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	АМТЗ-ийн талбай болон нөлөөллийн бүсийн айл өрх	-	-	Харилцан тохиролцооны үндсэн дээр	2024 он	“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл
Нийт						-		

1.4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнөх олборлолтын үе болон БОННУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл уулын ажлыг зогсоон сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах, цаашлаад нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэх хэрэгтэй. Мөн төсөл хэрэгжүүлэгч нь тухайн бүс нутгийн соёлын биет бус өвийг хамгаалах, хадгалах чиглэлээр компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлж болно.

Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	АМТЗ-ийн талбай орчим болон дотор байх түүх соёлын өвүүд	Олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрвэл	Шаардлагатай тохиолдолд дурсгалуудыг шилжүүлэх	-	-	-	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт						ҮАЗ		

1.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тэсрэх бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг аюулгүй хадгалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан болно.

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах							
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл	Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах	Уурхай ажиллах хугацаанд төслийн нийт арга хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	Онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
2	ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудын гадаргыг урсаас хамгаалах ба тэдгээрээс бодис зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах	Түлш, шатах тослох материал, тэсрэх бодисын агуулах	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	БНба дүрэм
3		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”- мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Төслийн хэрэгжих нийт хугацаанд		Үйл ажиллагааны зардал	2024 он	ЗГ-ын 2020 оны 190-р тогтоол
4		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчилга өгөх.	Төслийн хэрэгжих нийт хугацаанд		Үйл ажиллагааны зардал	2024 он	Гамшгаас хамгаалах хууль
Химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дунд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ							
	Нүүрсээр ажиллах халаалтын зуухан дах нүүрсний шаталт, түлшний бүтэц, уурын зуухны хэлбэр хэмжээ, шатаах нөхцөл, ачааллаас шалтгаалан үүсэх бохирдолт ЗДАаас хэтрэх эрсдэл үүсэх	Нүүрсний шаталтаас бий болох тоос, хүхрийн оксидууд (SOx), азотын оксидууд (NOx), Зарим шагдаггүй хэсгүүд буюу нүүрстөрөгчийн оксид (CO), бусад органик нэгдлүүд нь уурын зуухны үйл ажиллагааны нөхцөлөөс хамаарах тул аль ашиглаж буй уурын зуухын ажиллагаанд хяналт тавих	Уурхай ажиллах хугацаанд Төслийн нийт арга хэмжээнд				
	Тэсрэх бодис, шатах тослох материалын ашиглалт, хадгалалтаас хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Тэсрэх бодис, шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийг бүрдүүлэх,	Төслийн хүрээнд		ҮАЗ	2024 он	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, MNS 4628:2013. “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”
		Тэсрэх бодис, шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт орох	Бодис материалтай харьцаж ажилладаг ажилчид		200.0	2024 он	
	Тэсрэх бодис, шатах тослох материалын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Тэсрэх бодисын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Төслийн ашиглах ШТС		500.0	2024 он	
		Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай болгон, алдагдаж асарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх			1 900.0	2024 он	

Гал түймрээс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ							
	Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Нийт ажилчид		250.0	2024 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89 MNS 4628:2013. “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм”
		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах хуурайшилт ихтэй саруудад гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналтыг ойртуулах тавих	Уурхайн хотхон, Засварын газар Тэсрэх материалын агуулах ШТС-ийн талбайд		400.0	2024 он	
Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							
	Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Нийт ажилчид	-	ХАБЭА-н зардлаас	2024 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4990:2023
	Эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид	-	ХАБЭА зардал	2024 он	
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Нийт ажилчид		500.0	2024 он	
		Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Үйл ажиллагаанд ашиглаж буй машин маханализм				MNS 4969:2000
		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах	Нийт ажилчид,		ХАБЭА-н зардлаас	2024 он	
Нийт					3 750.0		

1.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож, байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтандаа хариуцуулан ажиллана. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7,8	Сар 9.10.11		
1	2	3	4	5	6	7	
	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх/5 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр		2026 онд		Уурхайн байгаль орчны ажилтан Уурхайн дарга	Газрын тухай хуулийн 58-р зүйл
	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх; Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;/2 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр		2025 онд			Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101
	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах	500			x	Уурхайн байгаль орчны ажилтан Уурхайн дарга	
	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	Үйл ажиллагааны зардал			x	Уурхайн байгаль орчны ажилтан	БОНБУ-ний тухай хууль
	Нийт зардал	500.0					

1.7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (охшх)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулж төлөвлөсөн болно.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллагад бодитой мэдээлэл өгөх зорилготой.

Жил бүр тухайн жилд хийгдсэн хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж байх нь цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналтын цэгийн байршил оновчтой эсэх, объектийг бүрэн хамарч буй эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Уурхайн үйл ажиллагаанд хийгдэж байгаа хяналт-шинжилгээний зорилго нь уурхайн үйл ажиллагааны үед гарах хаягдал болон бусад төрлийн бохирдуулагчдыг алдагдах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, оновчтой үзүүлэлтүүдийг сонгон авч хянах, урьдчилан харах бололцоогүй гэнэтийн осол гарсан тохиолдолд түүний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь оновчтой болгоход чиглэгдэнэ.

Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэн, жил бүр холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын холбогдох албадад хүргүүлж байх ёстой.

“Хартар”-ийн нүүрсний ордын үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн явцад жил бүрийн хяналт-шинжилгээний ажлын үр дүнг нутгийн иргэдэд мэдээлж, хяналт-шинжилгээний ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ нутгийн иргэдийн санал бодлыг тусгаж, нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллах нь зүйтэй.

“Биг могул коул энд энерги” ХХК нь зохих журмын дагуу (ОХШХ)-г амжилттай хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй.

Дээж авах, сорилт, хэмжилт хийх тоног төхөөрөмжийг зохих шаардлагын дагуу ажиллуулах, дадлагажиж, мэргэшсэн хүмүүсээр хэмжилт судалгаа хийлгэн, баримтжуулан тэмдэглэл хөтөлж, зураглал хийсэн байна.


Хяналт-шинжилгээний хэмжилтийн бүх мэдээллийг сайтар нягтлаж эцэслэн боловсруулсны дараа байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэн хадгална.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, мян.төг /жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
АГААРЫН ЧАНАР								
1	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт	Ил уурхайн салхины чиглэлийн доор Карьерын дотор дээд,	Жилд 4 удаа буюу улирал тутам	Тоосжилтын хяналтын явуулах мониторингийн 2 цэгт	33.0	264.0	MNS 4585:2016 MNS:3384:1982 MNS:4048:1988	PM2.5-0.05 мг/м3 PM10-0.1мг/м3
2	Бохирдлын цэгэн эх үүсвэр: SOx, NOx, COx	- Уурхайн гадаад, дотоод тээврийн замын хажууд	Жилд 4 удаа буюу улирал тутам	Бохирдуулагч хийн хяналт шинжилгээ явуулах мониторингийн 2 цэгт	50.0	400.0	MNS 4585:20216 MNS:3384:1982 MNS 4048:1988	ЗДХ
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС								
1	Гадаргын болон газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж,	Уурхайн шүүрлийн уснаас /1 цэгээс / Булаг -Мониторингийн цооног /шинээр байгуулна/	Жилд 4 удаа буюу улирал тутам	Нийт 2 цэг дээр дээжлэлт хийж шинжлэх	43.0	344.0	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-1:2004 MNS ISO 5667-5:2001 MNS 900-2018 MNS 6148;2010 MNS 4586 : 1998	ЗДХ
3	Газрын доорх усны түвшин, хэмжих	Мониторингийн цооног /шинээр байгуулах/ Гүний худаг	Улиралд 1 удаа	Нийт 2 цэг дээр хэмжилт	-	-	Хуваарийн дагуу	
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах	-Шимт хөрсний овоолго -Ил уурхайн дээд, доод хэсгээс болон уурхайгаас 10 км радиуст	Жилд 3 удаа Дулааны улиралд авах	Уурхайн бүсийн орчим мониторингийн 3 ш тогтмол цэгт	25.0	225.0	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991	ЗДХ
2	Хөрсний бохирдлын хэмжилт (цацраг идэвхт элементүүд, хүнд металлууд, нефть бүтээгдэхүүн,	-уурхайн эрүүл талбайгаас Хоосон чулуулгийн овоолго	Жилд 3 удаа Дулааны улиралд авах	Уурхайн бүсийн орчим мониторингийн 2 ш тогтмол цэгт	25.0	150.0	MNS5850 : 2019	ЗДХ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, мян.төг /жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
	органик бохирдуулагч);							
УРГАМЛАН НӨМРӨГ								
1	Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, Ургамлын дундаж өндөр, Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га;	-Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд	Жилд 3 удаа	Ургамлын хяналт шинжилгээг мониторингийн 2-3 цэгт		600.0	Ургамлын тухай хууль MNS 6191:2010 MNS 3474 : 2003	-
АМЬТНЫ АЙМАГ								
1	2-нутагтан, мөлхөгчид, шувууд, хөхтөн том, жижиг амьтдын: -Зүйлийн бүрэлдэхүүн -Тоо толгой (нягтшил) -Тархалт -Байршил нутаг -Шилжилт хөдөлгөөн - Амьдрах орчны ажиглалт	Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд	Жилд 2 удаа	Амьтны аймгийн судалгааг төсөл хэрэгжиж буй газар нутгийн орчимд		600.0	Амьтны тухай хууль, Ажиглах болон дээж талбайн тооллого Цэгэн ажиглалт, трансектийн аргууд	
ДУУ ЧИМЭЭ БА ДОРГИО ЧИЧИРГЭЭ								
1	Гадаад орчны дуу чимээ	Нийт тусгай зөвшөөрөл бүхий талбайд	Жилд 1 удаа	Хяналт шинжилгээ явуулах 2 мониторингийн цэг дээр		100.0	MNS 4585:2016	60дБ
2	Ажлын байрны дуу, чимээ	Ил уурхайн орчимд	Жилд 1 удаа	Шаардлагатай ажлын байрнууд дээр		100.0		85дБ
Нэг жилийн зардал					2783.0			

Зураг 1. ОХШХ-ийг мониторингийн цэгүүд



1.8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хуваарь

“Биг могул коул энд энерги” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар орон нутгийн байгаль орчны газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх үүрэгтэй. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

“Биг могул коул энд энерги” ХХК нь сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Баянжаргалан сумын багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4 - р улирал	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Дундговь аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Дундговь аймгийн төв
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Төрийн захиргааны төв байгууллага
	Нийт				ҮАЗ		

1.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

“Биг могул коул энд энерги” ХХК-ийн хэрэгжүүлж буй Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-007944 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хар тэвш” нэртэй нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн нийт зардал нь 41 383.0 мян.төг болно /дөчин нэгэн сая гурван зуун наян гурван мянган төгрөг/.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хэмжээг урьдчилсан байдлаар төлөвлөсөн бөгөөд Төрийн захиргааны байгууллагаас тавигдах нэмэлт шаардлага, байгалийн гамшиг, давагдашгүй бусад хүчин зүйлийн улмаас нэмэлт ажил хийх шаардлага гарах тохиолдолд зардлын хэмжээнд өөрчлөлт оруулахыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх нь зүйтэй болно.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Арга хэмжээ	Зардал, Мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	15 150.0
2	Нөхөн сэргээлт	6 000.0
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах	11 500.0
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 700.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 750.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500.0
9	Орчны хяналт шинжилгээ	2 783.0
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	-
	Нийт зардал, мян.төг	41 383.0